

Дүрслэн тайлбарласан эхийн  
дэвшүүлсэн асуудал, гол санаа,  
дүгнэлтийг тодорхойлох

8 анги

“Монголын говь нь говиороо байх болтугай” эхийг уншаад, танил бус үгийн утгыг тэмдэглээрэй.



Алтан утсаар торолж,  
сийрэгхэн нэхсэн зүйл

Хөлгүй гүн, маш гүн ус

“Дэлгэсэн тэрлэг шиг” монгол нутгийн хормойг **алтан шаа** утсаар эмжсэн элсэн манхан “далайнууд” үргэлжилнэ. Энэ элсэн далай элэр балрын эрт үедээ их усан далай байсан гэдэг домогтой. “Монголын нууц товчоо” зохиолын эхэнд монгол угсаатны уг гарвалын түүхийг өгүүлэхдээ “Дээд тэнгэрээс заяат төрсөн Бөртэ чоно, Гоо марал хоёр бөлгөө. Тэд тэнгис далайг гэтэлж, онон мөрний хөвөөнд ирж нутаглавай. Тэр цагт Батцагаан хэмээх нэгэн хөвүүн төрөв...” хэмээн монгол алтан ургийнхны хэлхээг аман түүхээр өгүүлдэг. Энд өгүүлж буй “тэнгис далай” нь даруй өдгөөгийн монголын өмнөд их говь эрт урьддаа **оломгүй** их далай байсан агаад одоо ч их говийн элсэн цөлийн доороос далайн аварга биет амьтад, үлэг гүрвэлийн араг яс, ховор сонин олдвор илэрц, эртний амьтдын ул мөр олдсоор байгаа билээ. (1)

# 1. Эхийг уншаад, танил бус үгийн утгыг тэмдэглээрэй

Алтан шаргал элсэн манхан, аварга динозаврын араг яс, өндөг, чулуужсан мод, элсэн далайн” хөлөг онгоц” гэгдэх хоёр бөхт тэжээвэр тэмээ, дэлхийн “Улаан ном”-д бүртгэгдсэн нэг бөхт зэрлэг хавтгай, цөөн тохиолдолд төрдөг **сарман**, эрээн алаг тахь, хулан гээд нэн ховор амьтад, хангайн үзэмжээс ч үл дутах үзэсгэлэнт сайхан Баянбүрд, түмэн наст тоорой, заг, төгөлдөр баян газрын хэвлий дээрх баялаг хийгээд газар доорх диваажин гэлтэй “Ёлын ам”, “Гурван сайхан уул”, говь гэмээнэ Хангайн нуруутай арсалдан өрсөлдөх “Ээж хайрхан”, “Ажийн нуруу”, “Арц богд”, “Алтайн цаадах говь” гээд сүрлэг сайхан уул нурууд, нүд алдам хөндий, аргаль янгирын сүрэг, хулангийн тоос, хармаг, гоёо, таана, хөмүүл гээд жимс ургамал, нүд алдам тал хөндий, далай мэт мэлтэлзэн туналзах хөх зэрэглээ, улаан хуй эргэлдэж босч элсээр шуурах **угалз**... гээд нэн сонин гайхамшигтай байгаль, байгалийн үзэгдэл, ан амьтадгүйгээр өмнийн цэнхэр говийг төсөөлөхийн ч аргагүй. (2)

Тэмээ хавтгай  
2-ын дундаас  
гарсан эрлийз


Говь цөлд  
болдог хүчтэй  
элсэн хуй салхи

# Үргэлжлэл

“Манай орны говийн бүсэд ямар ямар их говиуд ордог вэ?” гэдэг асуултад газар зүйн шинжлэх ухааны ахмад докторуудын нэг С.Жигж “Байгаль хамгаалал. 100 асуулт, хариулт” Уб., 1987. Ийнхүү хариулжээ. “Тус улсын нутгийн өмнөд хагас дахь говь, хагас цөлийн бүсэд орчин тойрныхоо газраас их өвс ургамалтай үржилт хөрс, цэнгэг устай баян бүрдүүд олон газар тааралдана. Ялангуяа Монгол Алтайн нурууны ар, өвөр хажууд Алтайн чанад дахь говь, Дорноговь, Дорнодын өргөн тал, Шаргын говь, Галбын говь зэрэг их говиуд, Онон, Таац, Туй зэрэг Хангайн нуруунаас эх авсан голуудын адаг орчим газраар их бага хэмжээний баянбүрдүүд нэн элбэг байдаг. Говийн баян бүрдүүдээс Эдрэнгийн нурууны ар говьд орших Баян тоорой, Алтайн цаадах говийн эхийн голын баян бүрдүүд маш үзэсгэлэнтэй нутаг юм. Монголын хамгийн уудам говь нутаг, говийн нууруудын хөндий, Алтайн өвөр говь, Эзгүй газар, Онч-Хяр, Умард говь, Дорноговийн Буурц хотгор, Замын-Үүдийн цав толгод, Их нууруудын хотгор, Цэнхэр номингийн говь, Галбын говь, Борцонжийн говь, Заг сүүжийн говь, Хүйсийн говь, Улаан говь, Борзонгийн говь зэрэг нүд алдам уудам говиуд бий. Эдгээр говиудад хар сүүлт, зээр, аргаль, янгир, хулан, хавтгай зэрэг ховор амьтад нэн элбэг байдаг.” (товхимлын 56-р тал) (3)

# Үргэлжлэл

“Утга суртлын бичиг”-т говийн тухай бичихдээ: “Дэлхийн бөмбөрцөг дээрх тэгш газар, уул усанд цөм амьтай бодис буй. Гагцхүү элсэн говь болбоос тиймгүй. Түүний зах хязгаарын өргөн их нь заримд мянгаад газар хүрэх буй. Тэрхүү газар болбоос ус, өвс ховор тул хүн суухад зохисгүй, бас үргэлж их салхи салхилаад, өвс чулууг эвхэн холилдуулж, огторгуйд хүргэх хийгээд гэнэт унахад хүн хийгээд адгуусыг бүрэлгэж болох бөгөөд түүнээс дутаан зайлж чадахгүй, ялангуяа өдөр болбоос **ээгэм** дулаан бөгөөд шөнө болоход онц тэсгэм хүйтэн болохоос гадна заримдаа хяруу, холимог цас шуурга цацрах тул аяны хүн ихэд гашуудна. Ертөнцийн туйлын их говь болбоос Африк тивийн хойд этгээдэд буй амуй. Бас манай Монгол улсад, Дундад улсын Шинжаан мужид цөм буй” хэмээн говь цөлийн хатуу бэрх, хүн амьдрахад хүнд хэцүү амьдралыг ийнхүү дүрсэлжээ. Энд өгүүлсэнчлэн говь цөл нь хангай, тал хээр бүсийн байгаль, цаг агаар, амьдрах орчин нөхцөлтэй харьцуулбал хүчир, бэрхшээлтэй нь үнэн боловч говь үргэлж хахир хатуу араншин гаргадаг, хүн нутаглахад хэцүү гэвэл өрөөсгөл дүгнэлт болно. Говийн сайхныг говьчууд л мэднэ.(4)



Нарны гэрэл,  
илч тусах

# Үргэлжлэл

Монголын говьд баян бүрдүүдийг хүний гараар цогцлоон бүтээж болно. Социалист нийгмийн үед Говь-Алтай аймгийн Халиун сумын нэгдлийн дарга Лодойхүү баатар говийг цэцэрлэгжүүлж, жимс жимсгэнэ, чацаргана, тарвас тариалж, зөгий үржүүлж, жимсний ундаа, дарс, архи үйлдвэрлэж, сум дундын үйлдвэр байгуулж үр ашигтай ажиллаж байсныг бидний үеийнхэн мэднэ.(5) Говийг баян бүрджүүлэх нөр ажлыг цаг алгуурлалгүй хийх, говьд олборлож буй ашигт малтмалын орд газрыг нөхөн сэргээх, хангайн том гол мөрнийг суваг татан говь руу урсган усжуулах, тариалан, жимс жимсгэний аж ахуй эрхлэх, тэжээлийн ургамал тарих, ан амьтныг хамгаалж, тоо толгойг өсгөх, говийн үзэмж төгөлдөр байгальтай газар аялал жуулчлалыг хөгжүүлэх ... гээд хийгүүштэй ажил маш их байна. Эдгээр ажлыг үе шаттай, төлөвлөгөөтэй, чанартай, үр дүнтэй хийж гүйцэтгэвэл манай говь сэргэн төлжих, өөрчлөгдөн шинэчлэгдэх боломжтой, дэлхийн олон улсад говь цөлийн байгалийг бүтээн байгуулж, хайрлан хамгаалах, нөхөн сэргээхийн үлгэр жишээг бид үзүүлж чадах болно. (6)

# Эхийн утгыг ойлгох

Цогцолборын дугаар	Цогцолборын утга санаа	Цогцолборын нэр	Эхийн гол санаа
1-р цогцолбор	Монголын говь эрт цагт усан далай байсан.	Элсэн далай	Говь говиороо байхдаа л гайхамшигтай.
2-р цогцолбор	Говийг сонин гайхамшигтэй байгаль, байгалийн үзэгдэл, ан амьтад, ургамалгүйгээр төсөөлөхийн аргагүй	Гайхамшигт говь	
3-р цогцолбор	Манай оронд үзэсгэлэнт сайхан их говиуд байдаг.	Монголын их говиуд	
4-р цогцолбор	Говьд амьдрах боломжтой.	Говийн амьдрал	
5-р цогцолбор	Монголын говьд баянбүрдийг хүн цогцлоон бүтээж болно.	Хүний бүтээсэн баянбүрд	
6-р цогцолбор	Говийг нөхөн сэргээх, өөрчлөн шинэчлэх, хайрлан хамгаалах ажлыг хийцгээе	Говио хайрлая	



# Зохиогч ямар эх сурвалжаас юуны тухай баримтыг ямар зорилгоор эш татсаныг бичээрэй.

№	Бүтээлийн нэр	Зохиогч	Баримт	Эш татсан зорилго
1	Монголын нууц товчоо	ААЗ	Бөртэ чоно, Гоо марал тэнгис далайг гаталж ирсэн тухай	Монголын элсэн цөл эрт дээр үед далай байсан гэдгийг батлахын тулд
2	Байгаль хамгаалал, 100 асуулт, хариулт. УБ, 1987. 56-р тал	С.Жигж	Монголын говийн бүсэд ордог говиуд тэдгээрийн байгаль, цаг уур , ан амьтдын тухай	Монголын говь өргөн уудам, үзэсгэлэнт сайхан гэдгийг батлахын тулд
3	Утга суртлын бичиг	Тодорхойгүй	Говьд амьд амьтан амьдрах боломжгүй хатуу ширүүн уур амьсгалтай байдаг тухай	Зарим хүмүүс говь бол амьд амьтан байх аргагүй халуун цөл байдаг гэж боддог төсөөллийг үгүйсгэхийн тулд

Зохиогч өөрийн хэлэх гэсэн санааг батлах, тодотгох, дэлгэрүүлэх зорилгоор эшлэл авдаг. Эшлэхдээ дараах зүйлийг анхаарна.

- Зохиогчийн нэр, ямар нэртэй ном , зохиол болох
- Хэдэн онд хэвлэгдсэн
- Хэддүгээр талаас авсан бэ? гэсэн мэдээлэл нь тодорхой байх ёстой.
- Авсан эшлэлээ хашилтад “ “ бичдэг.



# Дүрслэлийг ялгаж тайлбарлах

Юуг дүрсэлсэн	Яаж дүрсэлсэн	Яагаад ингэж дүрсэлсэн бэ?
Монгол нутаг	Дэлгэсэн тэрлэг шиг	Монголын газар нутгийг газрын зураг дээр дэлгэсэн тэрлэг шиг харагддаг хэлбэрээр нь, уудам цэлгэр гэсэн утгаар нь адилтган дүрсэлсэн байна .
МОНГОЛЫН ӨМНӨД ХЭСЭГ	Монгол нутгийн хормой	Монголын говь нутгийнхаа өмнөд хэсэгт байдаг гэдгийг дээлийн хормойтой адилтган дүрсэлжээ.
ГОВЬ	Алтан шаа утсаар эмжсэн элсэн манхан далай	Говийн элс шаргал өнгөтэй байдгийг алттай, Монголын өмнөд хил говиор зааглагдаж байгаа нь газрын зурагт алтан утсаар эмжсэнтэй адил харагддагийг ийнхүү дүрсэлсэн.

## 2-р цогцолборт байгаа дүрслэлийг ялган утгыг нь тайлбарлаарай.

Дүрсэлсэн хэсэг	Юуг дүрсэлсэн	Яагаад ингэж дүрсэлсэн бэ?
“далайн хөлөг онгоц” гэгдэх 2 бөхт тэжээвэр тэмээ	Тэмээ	Алсаас харахад зэрэглээн дундах тэмээ далайд хөвж байгаа хөлөг онгоц мэт харагддаг учраас
Газар доорх диваажин гэлтэй “Ёлын ам”, “Гурван сайхан уул”	“Ёлын ам”, “ Гурван сайхан уул”	Нар шарсан халуун говьд байдаг Гурван сайхан уул сүндэрлэн харагдах бөгөөд ургамал, ус,ховор амьтдаар баян. Мөн Ёлын амны булаг нь жилийн 4 улиралд мөстэй байдаг зуны аагим халуунд тэнд очиход сэрүү татан диваажин мэт байдгийг ийнхүү дүрсэлсэн.
Хангайн нуруутай арсалдан өрсөлдөх сүрлэг сайхан уул нурууд	Уул нурууд	Говийн уул нурууд нь хангайн өндөр уулстай эн зэрэгцэхүйц сүрлэг гэдгийг “ арсалдан өрсөлдөх” гэсэн үйл үгээр дүрсэлсэн байна.
Нүд алдам хөндий	Хөндий	Говийн хөндий нь уудам цэлгэр гэдгийг нүд алдам гэж дүрсэлсэн.
Далай мэт мэлтэлзэн туналзах хөх зэрэглээ	зэрэглээ	Говийн зэрэглээ нь алсаас харахад далай мэдтэлзэж байгаа мэт цэнхэрлэн туналзаж харагддаг.

# “Хүн сайтыг олж нөхөрлө”

Хэлц	Уран дүрслэл	Гол буюу тайлбарласан хэсэг
Нэгэн биеийн нөхөр Нимгэн хувцасны нөмөр	Адилтгал , тойруулал	Яагаад гэвэл, нөхрийн сайнаар хүн өөдөлж, нуурын сайнаар загас жаргаж явдаг гэдэг.
Нөхрийн сайнаар хүн өөдөлнө Нуурын сайнаар загас жаргана	Адилтгал	Нөмөр сайтай гэр дулаан байдгийн адил нөхөр сайтай хүн нөмөр нөөлөгтэй байна.
Хүн хүнийхээ хүчинд Загас усныхаа хүчинд	Адилтгал	Хүн хүнийхээ тус дэмээр амьдардаг
Аман дээрээ сүрхий Ачир дээрээ базаахгүй	Адилтгал	Хэлэх нь сайхан ч,хийх нь өөр ,сайхан ярьдаг ч үр дүн багатай.
Тэнэг нөхөр тээг садаа болно	Адилтгал	Тэнэг хүн амьдралд саад болох, тэнэг хүн тээг саадтай адил
Тэнэг хүн харагдах гэж урд нь бултганана Ухаантай хүн харах гэж ард нь үлдэнэ	Харшуулал	Тэнэг хүн өөрийгөө дөвийлгөж таниулахыг хичээдэг бол ухаантай хүн яарч үйлдэл хийдэггүй , аливаад буурьтай, бодолтой ханддаг Санааг эсрэгцүүлсэн

## Адилтгал:

Юмс үзэгдлийн аль нэг шинжийг товойлгон тодруулах зорилгоор түүнтэй төстэй өөр юм үзэгдлийн нэрээр утга шилжүүлэн дүрслэх найруулгын ур маяг юм. Адилтгал бол далд зүйрлэл юм.

## Харшуулал:

Хоёр ухагдахууны төстэй талыг биш харин эсрэг талыг заан илрүүлэхээр зэрэгцүүлэн тавьж дүрслэх найруулгын ур маяг юм.

# Дүгнэлт- Дүрслэн тайлбарласан эх

Дүрслэл ашиглах нь уншигчийн сонирхлыг татаад зогсохгүй уг эхэд илэрхийлж буй санааг илүү тодорхой болгодог. Ийм эхийг дүрслэн тайлбарласан эх гэдэг.

Дүрсэлж тайлбарлана гэдэг нь аливаа мэдээлэл тайлбарыг өгөхдөө уран сайхны дүрслэлээр дамжуулан тайлбарладаг байна.

1. Жишээ нь: Н.Багабандийн “ Хүн сайтыг олж нөхөрлө” эхэд нөхрийн сайнаар хүн өөдөлж, нуурын сайнаар загас жаргаж явдаг шиг найз нөхдөө зөв сонгон нөхөрлөх нь чухал. Сайн нөхөр амьдралын түшиг тулгуур бол муу найз үргэлж тээг саад болдог юм гэдгийг ойлгуулахын тулд тайлбарлах зорилгоор бичсэн. Ингэхдээ өгүүлбэрийг хэлэх аялгаар хэм тэнцүүлэн, толгой сүүл холбох, хэлц, зүйр цэцэн үгийг ашиглах гэх мэтээр дүрслэлийн олон аргыг ашиглан бичсэн байна.

2. “Монголын говь говиороо байх болтугай “ эхийн эхлэл хэсэгт “Монголын говийг адилтгалын аргыг ашиглан урнаар дүрсэлсэн бол гол хэсэгт хэд хэдэн эш татсан баримтыг оролцуулан говийн тухай мэдээлэн дүрслэн тайлбарласан. Төгсгөл хэсэгт говь нутгийг хамгаалахыг уриалж Монголын говь говиороо байх нь гайхалтай гэсэн санааг ойлгуулахыг зорьжээ.